



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 08 өдөр

Дугаар А/386

Хэрлэн сум

С.Донжидмаа-д буцалтгүй  
тусламж олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгийн уугуул Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн иргэн С.Донжидмаагийн өргөдлийн дагуу түүнд түрээсийн байрны төлбөр төлөхөд зориулж 1,000,000 (нэг сая) төгрөгийн буцалтгүй тусламж олгосугай.

2.Буцалтгүй тусламжид шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, нэг удаагийн буцалтгүй тусламж, дэмжлэгийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тэвьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010835